

ЗӨВШӨӨРЛИЙН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГИЙН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Зөвшөөрлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлд заасан Зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан /цаашид “Зөвшөөрлийн нэгдсэн сан” гэх/-г үүсгэж, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой явцын мэдээллийг зөвшөөрөл хүсэгч, эзэмшигчид тогтмол мэдээлэх, эрх бүхий этгээдийн олгосон зөвшөөрөл түүнд оруулсан өөрчлөлтийн шийдвэрийг санд бүртгэж байршуулах, сангаас иргэн, хуулийн этгээдэд лавлагаа, мэдээлэл өгөхтэй холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Зөвшөөрлийн нэгдсэн сангийн үйл ажиллагаанд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т заасан зарчмыг баримтална.

1.3. Энэ журамд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

1.3.1. “эрх бүхий этгээд” гэж Зөвшөөрлийн тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.2-т заасан этгээдийг;

1.3.2. “бүртгэх эрх бүхий байгууллага” гэж Зөвшөөрлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан этгээдийг;

1.3.3. “явцын мэдээлэл” гэж зөвшөөрөл хүссэн болон сунгуулах өргөдлийг шийдвэрлэх процесс ямар шатанд явааг харуулсан мэдээллийг;

1.3.4. “зөвшөөрлийг кодлох” гэж зөвшөөрлийн нэгдсэн бүртгэл хөтлөх зорилгоор бүртгэх эрх бүхий байгууллагаас баталсан аргачлалаар зөвшөөрлийг кодлохыг;

1.3.5. “зөвшөөрлийн бүртгэлийн маягт” гэж бүртгэх эрх бүхий байгууллагаас баталсан Зөвшөөрлийн нэгдсэн санд зөвшөөрөл, түүнд оруулсан өөрчлөлтийг бүртгэхэд шаардлагатай мэдээллийг агуулсан цахим болон цаасан маягтыг;

1.3.6. “зөвшөөрөлд оруулсан өөрчлөлт” гэдэгт зөвшөөрлийг сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохыг;

1.3.7. “лавлагаа” гэж Зөвшөөрлийн нэгдсэн санд үндэслэн зөвшөөрлийн мэдээллийн үнэн зөвийг нотолсон цахим болон цаасан баримт бичгийг;

1.3.8. “мэдээлэл” гэж Зөвшөөрлийн нэгдсэн санд бүртгэгдсэн зөвшөөрлийн шийдвэрүүд болон зөвшөөрлийг олгох, өөрчлөлт оруулсантай холбоотой мэдээллийн бүрдлийг.

Хоёр. Ерөнхий зүйл

2.1. Зөвшөөрлийн нэгдсэн сан нь Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1-т заасан “тусгай зөвшөөрөл”, 8.2-т заасан “энгийн зөвшөөрөл”-үүдийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох явцын мэдээлэл болон гарсан шийдвэрүүдээс бүрдэнэ.

2.2. Зөвшөөрлийн нэгдсэн санг үүсгэхдээ “Монгол хэлний компьютерын орчны тогтолцоо, кирилл болон монгол үсгийн нэгдсэн код “MNS 5552:2005” стандартыг дагаж мөрдөнө.

Гурав. Зөвшөөрлийн нэгдсэн санг үүсгэх

3.1. Эрх бүхий этгээд зөвшөөрөл хүссэн болон сунгуулах өргөдлийг Зөвшөөрлийн нэгдсэн сан эсвэл өөрийн зөвшөөрөл олгох зориулалт бүхий системээр хүлээн авч бүртгэн, холбогдох байгууллага, албан тушаалтанд хуваарилж, энэ тухай мэдэгдлийг өргөдөл гаргагчид цахимаар илгээнэ.

3.2. Өргөдлийн бүртгэл, холбогдох байгууллага, албан тушаалтан хянаж, хэрхэн шийдвэрлэж буй явцын мэдээллийг тухай бүр Зөвшөөрлийн нэгдсэн санд илгээж өргөдөл гаргагчид мэдээллэх ба өргөдөл гаргагч өөрийн өргөдлийн шийдвэрлэлтийн явцын мэдээллийг сангаас харах боломжтой байна.

3.3. Эрх бүхий этгээд нь зөвшөөрөл олгосон болон зөвшөөрөлд оруулсан өөрчлөлтийг Зөвшөөрлийн тухай хуулийн 5.3 дугаар зүйлийн 9-д заасны дагуу шийдвэр гарснаас хойш ажлын 2 өдрийн дотор Зөвшөөрлийн нэгдсэн санд бүртгүүлэх хүсэлтийг гаргана.

3.4. Эрх бүхий этгээд нь зөвшөөрөл олгосон болон зөвшөөрөлд оруулсан өөрчлөлтийг Зөвшөөрлийн нэгдсэн санд бүртгүүлэх хүсэлтийг дор дурдсан материалын хамт бүртгэх эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.

3.4.1. Зөвшөөрлийн бүртгэлийн цахим эсвэл цаасан маягт /бүрэн бөглөсөн байх/;

3.4.2. Зөвшөөрлийг олгосон болон түүнд оруулсан өөрчлөлтийг баталсан шийдвэр;

3.5. Бүртгэх эрх бүхий байгууллага нь Зөвшөөрлийн нэгдсэн санд бүртгүүлэхээр ирүүлсэн хүсэлтийг энэ журмын 3.4-т заасан шаардлагыг хангасан эсэхийг хянаж, кодоор бүртгэлжүүлэн, ажлын гурав хоногийн дотор бүртгэнэ.

3.6. Бүртгэх эрх бүхий байгууллага нь энэ журмын 3.4-т заасан шаардлага хангаагүй хүсэлтийг ажлын 3 хоногийн дотор хүсэлт ирүүлсэн эрх бүхий этгээдэд буцаах ба буцаасан үндэслэлийг тодорхой дурдана.

3.7. Энэ журмын 3.6-т зааснаар хүсэлтийг буцаасан тохиолдолд эрх бүхий этгээд хүсэлт буцаагдсан шалтгаан, нөхцөлийг арилгаж ажлын 3 хоногт багтаан дахин бүртгүүлэх хүсэлтийг хүргүүлнэ.

3.8. Зөвшөөрлийн болон түүний мэдээллийн үнэн зөв байдлыг эрх бүхий этгээд хариуцана.

3.9. Зөвшөөрөл эзэмшигч нь Зөвшөөрлийн нэгдсэн санд орсон зөвшөөрөлтэй холбоотой мэдээллийг бүрэн бус, алдаатай гэж үзвэл залруулах хүсэлтийг эрх бүхий этгээдэд гаргана.

Дөрөв. Зөвшөөрлийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх

4.1. Бүртгэх эрх бүхий байгууллага нь Зөвшөөрлийн нэгдсэн санг дор дурдсан журмаар эрхлэн хөтөлнө.

4.1.1. Бүртгэх эрх бүхий байгууллага нь Зөвшөөрлийн нэгдсэн сангийн мэдээллийг цахим хуудсаар дамжуулан эрхлэн хөтөлнө.

4.1.2. Зөвшөөрлийн нэгдсэн сангийн цахим хуудсанд байршуулсан зөвшөөрлийн мэдээллийг үйл ажиллагааны ангилал, олгосон эрх бүхий байгууллагаар бүлэглэж, цэс үүсгэх, хайлтын системд хайлт хийх, цахим хуудасны бусад мэдээлэлтэй холбогдох боломжтой байдлаар байршуулна.

4.1.3. Зөвшөөрлийн нэгдсэн санд зөвшөөрлийн мэдээллийг байршуулах, нийтлэх, шинэчлэх, цахим хуудасны хэвийн тасралтгүй үйл ажиллагааг хариуцах албан хаагч (цаашид "эрх бүхий ажилтан" гэх)-ийг бүртгэх эрх бүхий байгууллага нь томилон ажиллуулж, үйл ажиллагаанд нь хяналт тавина.

4.1.4. Цахим хуудсанд эрх бүхий ажилтны нэр, албан тушаал, холбоо барих мэдээллийг нийтэлнэ.

4.1.5. Цахим хуудсанд байршуулж нийтэлсэн мэдээллийг шинэчлэх тохиолдолд шинээр веб холбоос оноож, өмнөх хувилбарыг архивлаж, хандах боломжийг бүрдүүлнэ.

4.1.6. Цахим хуудсыг шинэчлэх, эсхүл шинээр үүсгэх тохиолдолд архивласан болон байршуулж нийтэлсэн нээлттэй мэдээллийг тухайн байршуулж нийтэлсэн огноогоор шинэ цахим хуудсанд хуулах, эсхүл устахгүй байхаар шинэчлэлийг хийнэ.

4.1.7. Зөвшөөрлийн нэгдсэн сангийн байнгын тасралтгүй үйл ажиллагаа, хадгалалт, хамгаалалт, мэдээллийн нууцлалыг бүртгэх эрх бүхий байгууллага хариуцаж ажиллана.

4.1.8. Зөвшөөрлийн нэгдсэн санг бусад төрийн байгууллагын зөвшөөрөл олгодог цахим системтэй холбон мэдээллийг бодит цагийн горимд солилцон ажиллаж болно.

Тав. Иргэн, хуулийн этгээдэд лавлагаа, мэдээлэл өгөх

5.1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан нээлттэй мэдээллийг Зөвшөөрлийн нэгдсэн сангийн цахим хуудсанд иргэн, хуулийн этгээд үнэ төлбөргүй үзэж, ашиглах боломжтой байршуулна.

5.2. Зөвшөөрлийн нэгдсэн сангаас олгох лавлагаа нь QR кодоор баталгаажсан байна.

Зургаа. Бусад зүйл

6.1. Бүртгэх эрх бүхий байгууллага нь Зөвшөөрлийн нэгдсэн сангийн тайлан, мэдээг жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан Засгийн газарт танилцуулна.

6.2. Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

- о о о -